



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар A/27

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.1.3, 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудлын хэрэглэлээр буулт үйлдэх систем, зайд хэмжих төхөөрөмж /ILS/DME/, “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын хэрэглэлээр буулт үйлдэх систем, зайд хэмжих төхөөрөмж /ILS/DME/, бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч, зайд хэмжих төхөөрөмжийг /DVOR/DME/ нислэгээр шалган баталгаажуулах ажил” хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: Г.Мөнгөнхуяг

Агаарын навигацийн үйлчилгээний газрын дэд
дарга

Нарийн бичгийн

дарга: Г.Бат-Алдар

Худалдан авах ажиллагааны тасгийн
мэргэжилтэн

Гишүүд: Г.Энэбиш

Нислэгийн журам боловсруулалтын албаны
менежер

Л.Бат-Оргил

Монголын Аэронавигаци, инженер техникийн
ажилтнуудын холбооны гишүүн

С.Байгалмаа

Сэтгэл зүй, судалгаа мэдээллийн төв төрийн
бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Г.Мөнгөнхуяг/-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Г.Бат-Алдар/-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.МӨНХЖАРГАЛ

